

## ОЮУТАН ДАДЛАГАЖУУЛАХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Оюутан дадлагажуулах журам /цаашид “журам” гэх/-ын зорилго нь гадаад улс болон дотоодын их, дээд сургууль, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд “Тавантолгой ХК /цаашид “Компани” гэх/-ийн **тэтгэлгээр суралцаж байгаа** болон бусад оюутнуудыг уурхайд дадлагажуулах, дадлага хийх хүсэлт гаргасан оюутнуудын бүрдүүлэх материал, мөрдөх дэг журам, эрх, үүрэг, хариуцлага, гарах зардалтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Оюутан нь танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг өөрийн удирдамжийн дагуу хийх бөгөөд дадлага хийх хугацаандаа энэхүү журам, компанийн Хөдөлмөрийн дотоод журам, бусад холбогдох дүрэм, журам, зааврыг мөрдөнө.
- 1.3 Танилцах дадлага нь мэргэжлийн суурь хичээлээр эзэмшсэн онолын мэдлэгтээ түшиглэн практик амьдралын ажиглалт хийж улмаар мэргэших чиглэлээ сонгоход туслалцаа үзүүлэх зорилготой бөгөөд эзэмшиж буй мэргэжлийн дагуух компанийн нэгжийн үйл ажиллагаатай танилцаж дүн шинжилгээ хийх зэргээр явагдана.
- 1.4 Үйлдвэрлэлийн дадлага нь танхимд эзэмшсэн онолын мэдлэг, чадварт түшиглэн оюутны практик чадвар, дадлыг баяжуулах зорилгоор тодорхой нэг байгууллагад мэргэжлийн хичээлээр тусгайлан зохион байгуулж буй сургалтын нэг хэлбэр байна.
- 1.5 Энэхүү журам нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

### ХОЁР. ДАДЛАГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ТҮҮНИЙ НӨХЦӨЛ

- 2.1 Оюутныг дадлагажуулах ажлыг компанийн Хүний нөөц, ХАБ-н ажилтантай хамтран хариуцан гүйцэтгэнэ.
- 2.2 Дараах оюутнууд компанид танилцах болон үйлдвэрлэлийн дадлага хийж болно. Үүнд:
  - 2.2.1. **Компанийн тэтгэлгээр суралцаж байгаа оюутнууд**
  - 2.2.2. **Журмын 2.3-д заасан шаардлага хангасан оюутан**
- 2.3 Дадлага хийх оюутан нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:
  - 2.3.1 Дадлага хийхийг хүссэн өргөдөл,
  - 2.3.2 **Оюутны дэлгэрэнгүй анкет**
  - 2.3.3 **Сурлагын дүнгийн жагсаалт**
  - 2.3.4 Тухайн сургуульд суралцаж байгаа нь үнэн болохыг баталсан сургуулийн тодорхойлолт,
  - 2.3.5 Тухайн сургуулиас олгосон дадлагын удирдамж,
  - 2.3.6 Оюутны үнэмлэх,
  - 2.3.7 Иргэний үнэмлэхний хуулбар

- 2.4 Оюутан нь энэхүү журмын 2.3-т заасан материалыг бүрдүүлж ХНС-ын менежер танилцуулна.
- 2.5 **ХНС-ын менежер нь оюутны суралцаж буй сургууль, мэргэжил, голч дүн, судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний бүтээлийн сэдэв зэрэг материалыг гүйцэтгэх захиралд танилцуулж дадлага хийх зөвшөөрлийг авна.**
- 2.6 Танилцах дадлагын хугацаа 14 хоногоос, үйлдвэрлэлийн дадлагын хугацаа 21 хоногоос хэтрэхгүй байна.
- 2.7 МСҮТ-ийн оюутан, сурагчид техник, хүнд механизм дээр дадлага хийх тохиолдолд сургуультай нь гэрээ хийгдэж техникийн элэгдэл хорогдол болон шаардлагатай түлш шатахууны зардалыг гаргуулсан байна.
- 2.8 Оюутан нь ХН, ХАББОЭА-н албанд 1 хоног дадлагажиж компанийн бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журам, заавартай танилцах бөгөөд дараагийн өдрөөс өөрийн суралцаж буй чиглэлийн дагуу холбогдох нэгжид дадлагаа үргэлжлүүлнэ.
- 2.9 Оюутанд дадлагын хугацаанд нь компанийн “Нууцын журам”-д бүртгэгдсэн баримт, мэдээллийг танилцуулахыг хориглоно.
- 2.10 ХНСургалт хариуцсан менежер нь дараах үйл ажиллагааг явуулна. Үүнд:
- 2.9.1** Дадлага хийх зөвшөөрөл авсан оюутанд компанийн Хөдөлмөрийн дотоод журам, энэхүү журам, холбогдох бусад дүрэм, журам, зааврыг танилцуулж, баталгааны маягтад /хавсралт 1/ гарын үсэг зуруулан нэг хувийг оюутанд өгч, үлдэх хувийг оюутны материалд хавсаргах,
- 2.9.2** Дадлага хийж буй оюутнуудын нэгдсэн санг хөтлөх, бүртгэх, журмын 2.3-т заасан материалыг хадгалах,
- 2.9.3** Оюутныг дадлага хийх нэгжийн удирдлагад танилцуулах, дадлагын удирдагчийг томилуулах ажлыг зохион байгуулах,
- 2.9.4** **Компанид дадлага хийх оюутны хоолны мөнгийг журмын 4.2-т заасны дагуу тухайн оюутнаас гаргуулан авч Захиргаа, санхүүгийн албанд тушаасан байна.**
- 2.11 Оюутны дадлагын хугацаа дуусахад ХНС-ын менежер дадлага хийсэн алба, нэгжийн удирдлагын үнэлгээ, **дадлагын тайланг** харгалзан тодорхойлолт гаргана. Тодорхойлолтод нэгжийн удирдлагын үнэлгээ, дадлагын тайланг хавсаргана.

## ГУРАВ. ОЮУТНЫ ҮҮРЭГ

- 3.1 Сурч байгаа сургуулийнхаа холбогдох албан тушаалтны гарын үсэг, тэмдгээр баталгаажсан удирдамжтай байна.
- 3.2 **Удирдамжийн дагуу дадлага хийх төлөвлөгөөг боловсруулж, дадлага удирдагчаараа батлуулах,**
- 3.3 Компанийн аливаа бичиг баримттай танилцахдаа дадлагын удирдагч болон эрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авна.
- 3.4 Дадлага хийж байх хугацаандаа гадны байгууллагын хүмүүс болон компанийн ажилтнуудтай соёлч боловсон харилцана.
- 3.5 Компанид баримталдаг бүх дүрэм, журам, зааврыг чанд баримтлан ажиллана.
- 3.6 Дадлагын удирдамжид тусгагдаагүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 3.7 Нууцын зэрэглэлтэй мэдээллийг олж авахыг завдах, дадлага хийх хугацаандаа олж мэдсэн компанитай холбоотой мэдээллийг гадагш задруулах, түгээхийг хориглоно.

## **ДӨРӨВ. ДАДЛАГА ХИЙХТЭЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ, ЦАЛИН ХӨЛС**

- 4.1. Журмын 2.2.2-т заасан оюутан нь дадлага хийхтэй холбогдон гарах бүх зардлыг буюу журмын 4.3-т зааснаас бусад зардлаа өөрөө хариуцна.
- 4.2. Компанид дадлага хийх оюутны нэг өдрийн хоолны мөнгийг компани дээр мөрдөгдөж буй тарифын дагуу тооцож, оюутнаас дадлага хийхээс өмнө урьдчилан гаргуулж авна.
- 4.3. Оюутан дадлага хийх тохиолдолд байрлах байр, орон сууцаа өөрөө хариуцана.
- 4.4. Журмын 2.2.1-д заасан оюутны компанийн нэгжид дадлага хийхтэй холбогдон гарах бүхий л зардлыг компани хариуцна.
- 4.5. Журмын 2.2.1, 2.2.2-т заасан оюутанд дадлага хийх хугацаанд нь зайлшгүй шаардлагаар өөрт тохирсон ажил хийвэл цалин хөлс олгох асуудлыг компанийн гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

## **ТАВ. ХАРИУЦЛАГА**

- 5.1 Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд компанийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцно.
- 5.2 Оюутан нь компанийн ёс зүйн хэм хэмжээнд харшилсан зөрчлийг гаргасан тохиолдолд дадлагыг хугацаанаас нь өмнө зогсооно.
- 5.3 Оюутан нь дадлага хийх хугацаандаа компанийн эд хөрөнгийг үрэгдүүлсэн, гэмтээсэн, компанид хохирол учруулсан тохиолдолд учруулсан хохирлоо бүрэн нөхөн төлж барагдуулна.
- 5.4 Оюутан нь дадлага хийхдээ энэхүү журмыг баримтлаагүй тохиолдолд дадлага удирдагчийн зүгээс харьяалагдах их, дээд сургуулийн захиргаанд мэдэгдэж, дадлага хийлгэхээс татгалзах эрхтэй.
- 5.5 Энэ журмын 3.7-д заасан зөрчил гаргасан тохиолдолд дадлагын үйл ажиллагааг нэн даруй зогсоож, зөрчлийг шалгуулахаар хуулийн байгууллагад шилжүүлнэ.

## **ЗУРГАА. БУСАД**

- 5.1. **Журамд ХНС-ын менежерийн саналаар компанийн гүйцэтгэх захирлын тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулна.**
- 5.2. **Журмын хэрэгжилтэд Дотоод хяналт хяналт тавьж ажиллана.**

**БАТАЛГАА**

/Компанид үлдэх хувь/

20...он ...сар ...өдөр

Дугаар.....

.....улсын .....сургуулийн  
н .....-р курст .....  
чиглэлээр ..... суралцаж  
байгаа ..... /овог,  
нэрээ бичих/ би “Тавантолгой” ХК-д ..... хоногийн **танилцах, үйлдвэрлэлийн** дадлага /доогуур нь зурах/ хийх хугацаандаа компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журам, зааврыг чанд мөрдөж, дадлагын хугацаанд олж мэдсэн компанитай холбоотой мэдээллийг бусдад тараахгүй.

Хэрэв дээрх журмыг зөрчсөнөөс болон мэдээллийг бусдад тарааснаас компанид хохирол учирсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээхээ баталж байна.

Баталгаа гаргасан:

.....хаягт оршин  
суух, .....регистрийн дугаартай ...../овог,  
нэрээ бичих/

Гарын үсэг .....

Баталгаа гаргуулсан:

ХН сургалт хариуцсан менежер ...../ /

**БАТАЛГАА**

/Оюутанд үлдэх хувь/

20...он ...сар ...өдөр

Дугаар.....

.....улсын .....сургуулийн  
н .....-р курст .....  
чиглэлээр ..... суралцаж  
байгаа ..... /овог,  
нэрээ бичих/ би “Тавантолгой” ХК-д ..... хоногийн **танилцах, үйлдвэрлэлийн** дадлага /доогуур нь зурах/ хийх хугацаандаа компанийн Хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журам, зааврыг чанд мөрдөж, дадлагын хугацаанд олж мэдсэн компанитай холбоотой мэдээллийг бусдад тараахгүй.

Хэрэв дээрх журмыг зөрчсөнөөс болон мэдээллийг бусдад тарааснаас компанид хохирол учирсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээхээ баталж байна.

Баталгаа гаргасан:

.....хаягт оршин  
суух, .....регистрийн дугаартай ...../овог,  
нэрээ бичих/

Гарын үсэг .....

Баталгаа гаргуулсан:

ХН сургалт хариуцсан менежер ...../ /